

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны ... сар ... өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2013 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуулийн 3, 4 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/3 дугаар зүйл:

3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын санд 2013 оны төсвийн жилд Төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1.	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	971,537.5
	1.1 Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	408,951.2
	1.2 Ажиллагсдаас төлөх шимтгэл	375,653.6
	1.3 Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	133,272.8
	1.4 Нөхөн олговор авагчийн нийгмийн даатгалын шимтгэл	6.2
	1.5 Хүний хөгжил сангаас төлөх иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэл	12,151.5
	1.6 Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	19,926.4
	1.7 Эрүүл мэндийн даатгалын бусад даатгуулагчийн төлөх шимтгэл	2,167.3
	1.8 Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	1,400.0
	1.9 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	919.9
	1.10 Бусад орлого	17,088.5
2.	Сангийн сайд	268,576.2
	2.1 Улсын төсвөөс олгох татаас, шилжүүлэг	268,576.2
	Нийт орлого	1,240,113.7

2/4 дүгээр зүйл:

4 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид дор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1.	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	
	1.1 Тэтгэврийн даатгалын сан	813,795.0
	1.2 Тэтгэмжийн даатгалын сан	57,486.0
	1.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	31,935.6
	1.4 Ажилгүйдлийн даатгалын сан	14,075.9
	1.5 Эрүүл мэндийн даатгалын сан	126,646.5
	1.6 Шүүхийн шийдвэр биелүүлэх албаны төлбөр	108.1
	1.7 Үйл ажиллагааны урсгал зардал	18,376.8

1.8 Хөрөнгийн зардал	5,383.0
Нийт зарлага	1,067,806.9

2 дугаар зүйл: Энэ хуулийг 2013 оны ... сарын ... -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ